



ЦЭБЭ КОНСАЛТИНГ АУДИТ ХХКОМПАНИ

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Монголсекюритиес ҮЦК ХК-ийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: СТА-2024-149-ААН

Улаанбаатар хот
2024 он

ЦЭБЭ КОНСАЛТИНГ АУДИТ ХХК
Хуудас: ...1..



Монголсекюритиес ҮЦК ХК-ийн
Удирдлага танаа

ЦЭБЭ КОНСАЛТИНГ АУДИТ ХХК

Монгол улс, Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Амарын гудамж-2,
Адмон групп ХХК-н байр 206 тоот
Утас: +976-77114235, +976-99994235
И-мэйл: audit@tsebeconsulting.mn
Вэбсайт: www.tsebeconsulting.mn

2024-03-29

№

24/149

танай _____ -ны № _____ -г

ХАРААТ БУС АУДИТЫН ТАЙЛАН

Аудитын дүгнэлт:

Бид Аудитын тухай хуулийн 9.1.1-д заасны дагуу Монголсекюритиес ҮЦК ХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон Санхүү байдлын тайлан, Орлогын дэлгэрэнгүй тайлан, Өмчийн өөрчлөлтийн тайлан, Мөнгөн гүйлгээний тайлан, эдгээр санхүүгийн тайлантай холбоотой нэмэлт тодруулга болон нягтлан бодох бүртгэлийн бодлогын хүрээнд санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар эдгээр санхүүгийн тайлангууд нь бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн тайлагналын Олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу материаллаг алдаа, зөрчилгүй, үнэн зөв илэрхийлэгдсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл:

Бид аудитын ажлаа Аудитын олон улсын стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Нягтлан бодогчдын ёс зүйн олон улсын стандартын зөвлөл (НБЁЗОУСЗ)-өөс гаргасан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм, Монгол улсын аудитын тухай хуулиар санхүүгийн тайлангийн аудитад тавигддаг ёс зүйн шаардлагын дагуу бид үйлчлүүлэгч компаниас хараат бус бөгөөд ёс зүйн шаардлагаа бүрэн биелүүлсэн.

Санхүүгийн тайланд удирдлагын хүлээх үүрэг, хариуцлага:

Санхүүгийн тайлангуудыг СТОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу бэлтгэж, үнэн зөв толилуулах, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг холбогдох стандарт, хуульд нийцүүлэн боловсруулж, тогтмол мөрдөж ажиллах нь компанийн удирдлагын үүрэг болно.

Мөн санхүүгийн тайлангуудыг заль мэх, алдаанаас үүдэлтэй буруу илэрхийллээс ангид бэлтгэж шударгаар толилуулахтай холбоотой дотоод хяналтын системийг бий болгон ажиллуулах, нягтлан бодох бүртгэлийн тохиромжтой бодлогуудыг сонгож хэрэглэх, байгууллагын үйл ажиллагааны болон нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурь зарчмыг хангаж ажиллах нөхцөл байдалд тохируулан нягтлан бодох бүртгэлийн тооцооллуудыг хийж ажиллах нь байгууллагын удирдлагын хариуцлага юм.

Аудиторын хүлээх үүрэг хариуцлага:

Бидний үүрэг бол гүйцэтгэсэн аудитдаа тулгуурлан эдгээр санхүүгийн тайлангуудад алдаа эсвэл залилангийн улмаас материаллаг буруу илэрхийллээс ангид

эсэхэд дүгнэлт өгөх явдал юм. АОУС нь санхүүгийн тайлангуудад материаллаг зөрчилгүй илэрхийлэгдсэн эсэх талаарх зохих нотолгоог олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, ёс зүйн шаардлагуудыг баримтлан гүйцэтгэхийг биднээс шаарддаг.

Иймд тодорхой дүгнэлтэд хүрэхийн тулд АОУС-д нийцүүлэн боловсруулсан горимын дагуу шалгалт хийж, хангалттай, тохиромжтой баримт нотолгоо цуглуулах үүрэгтэй.

Аудитын ажил нь санхүүгийн тайлан дахь дүн болон тодруулгын үндэслэлийг төстийн үндсэн дээр шалгаж батлах ажлыг багтаадаг. Санхүүгийн тайлангууд нь алдаа, залилангийн улмаас гарч болох материаллаг буруу тайлагналтай байж болох эрсдэлийг үнэлэх зэрэг горимуудыг аудитор өөрийн шийдлээр сонгож авна. Тэдгээр эрсдэлийн үнэлгээг байгууллагын дотоод хяналтын системийн үр нөлөөтэй байдлын талаар дүгнэлт гаргах зорилгоор биш тухайн нөхцөл байдалд зохистой аудитын горимуудыг зохиохын тулд санхүүгийн тайлангуудыг бэлтгэх, үнэн зөв танилцуулахтай холбоотой дотоод хяналтыг аудитор авч үздэг.

Түүнчлэн аудитын ажил нь санхүүгийн тайланг бүхэлд нь үнэлэхээс гадна, удирдлагын зүгээс хийсэн тооцооллууд, хэрэглэсэн бүртгэлийн зарчмуудыг шалгах ажлыг өөртөө агуулдаг.

Бидний гүйцэтгэсэн аудит нь аудитын дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоогоор хангагдсан гэж бид итгэж байна.

Хэрэглээний хязгаарлалт:

Энэхүү тайлан нь Монгол улсын "Компанийн тухай хууль"-ийн 94-р зүйлд заасан хуулийн этгээд болох хувьцаа эзэмшигчийн хүсэлтийн дагуу зөвхөн компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулагдсан ба аливаа нэгэн өөр зорилго агуулаагүй болно.



Д.ЭНХБААТАР
/Аудитор, МНБ/

1.АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**1.1 Аудитлагдсан санхүүгийн байдлын тайлан**

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	13,061,575.73	13,317,445.47
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	177,128.25	177,128.25
1.1.5	Санхүүгийн хөрөнгө	1,056,071,919.59	1,033,563,357.49
1.1.5.1	Арилжааны үнэт цаас	12,293,899.59	12,293,899.59
1.1.5.2	Борлуулахад бэлэн үнэт цаас	1,043,778,020.00	1,021,269,457.90
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,069,310,623.57	1,047,067,931.21
1.2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ		
1.2.1	Үндсэн хөрөнгө	9,728,800.00	9,728,800.00
1.2.1.1	Хуримтлагдсан элэгдэл	(5,435,102.02)	(6,407,902.02)
1.2.2	Биет бус хөрөнгө	-	-
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	4,293,697.98	3,320,897.98
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,073,604,321.55	1,050,378,829.19
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	219,022,631.00	261,122,631.00
2.1.1.3	Татварын өглөг	4,893,145.69	7,867,382.08
2.1.1.4	Нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг	5,218,559.32	15,467,239.32
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	229,134,336.01	284,457,252.40
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат өр төлбөр	-	-
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
2.2	Өр төлбөрийн нийт дүн	229,134,336.01	284,457,252.40
2.3	ЭЗДИЙН ӨМЧ		
2.3.2	Өмч-Хувийн	300,000,000.00	300,000,000.00
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	1,043,778,020.00	1,021,269,457.90
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(499,308,034.46)	(555,347,881.11)
2.3.9.1	Тайлангийн үеийн ашиг	(65,121,658.73)	(56,039,846.65)
2.3.9.2	Өмнөх үеийн ашиг	(434,186,375.73)	(499,308,034.46)
2.3.10	Эздийн өмчийн дүн	844,469,985.54	765,921,576.79
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	1,073,604,321.55	1,050,378,829.19

1.2 Аудитлагдсан орлогын дэлгэрэнгүй тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	Үйл ажиллагааны орлого	237,750.00	500,354.66
1.4	Брокерийн үйл ажиллагааны орлого	228,000.00	500,354.66
1.7	Бусад үйл ажиллагааны орлого	9,750.00	-
2	Борлуулалт, маркетингийн болон ерөнхий удирдлагын зардал	34,664,281.35	56,540,201.31
4	Санхүүгийн зардал	110,400.00	-
10	Бусад зардал	-	-
11	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(169.95)	-
12	Үнэт цаасны ханшийн зөрүүний олз (гарз)	-	-
14	Бусад ашиг (алдагдал)	-	-
15	Татвар [*] төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(34,537,101.30)	(56,039,846.65)
16	Орлогын татварын зардал	-	-
19	Татварын дараах ашиг (алдагдал)	(34,537,101.30)	(56,039,846.65)

1.3 Аудитлагдсан өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	Нийт дүн
2022 оны 1-р сарын 1-рх үлдэгдэл	300,000,000.00	280,911,684.70	(434,186,375.73)	146,725,308.97
Өмчид гарсан өөрчлөлт		762,866,335.30	-	762,866,335.30
Тайлант үеийн үр дүн	-	-	(65,121,658.73)	(65,121,658.73)
2022 оны 12-р сарын 31-рх үлдэгдэл	300,000,000.00	1,043,778,020.00	(499,308,034.46)	844,469,985.54
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	-	(22,508,562.10)	-	(22,508,562.10)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	300,000,000.00	1,021,269,457.90	(499,308,034.46)	821,921,576.79
Тайлант үеийн үр дүн	-	-	(56,039,846.65)	(56,039,846.65)
2023 оны 12-р сарын 31-рх үлдэгдэл	300,000,000.00	1,021,269,457.90	(555,347,881.11)	765,921,576.79

1.4 Аудитлагдсан мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	59,135,679.81	22,652,354.66
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	290,871.85	500,354.66
1.1.2	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	-	152,000.00
1.1.3	Татаас санхүүжилтийн орлого	58,678,000.00	22,000,000.00
1.1.4	Хүлээн авсан ногдол ашиг	48,209.00	-
1.1.5	Бусад мөнгөн орлого	118,598.96	-
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	58,963,859.26	22,351,506.92
1.2.1	Ажиллагчдад төлсөн мөнгө	40,796,652.00	17,933,680.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	10,423,200.00	-
1.2.3	Ашиглалтын зардалд төлсөн	2,525,986.00	1,119,606.00
1.2.4	Татварын байгууллагад төлсөн	725,108.25	185,319.61
1.2.5	Даатгалын төлбөрт төлсөн мөнгө	450,000.00	-
1.2.6	Зохицуулалтын хөлс, шимтгэл хураамжид төлсөн мөнгө	4,001,500.00	2,954,901.31
1.2.7	Бусад мөнгөн зарлага	41,413.01	158,000.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны ЦМГ-ний дүн	171,820.55	300,847.74
2	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮА-НЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
2.1.1	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
2.2.1	Үл хөдлөх хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө		
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны ЦМГ-ний дүн	-	-
3	САНХҮҮГИЙН ҮА-НЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	17,937,894.58	-
3.1.1	Бусад мөнгөн орлого	17,937,894.58	
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	18,067,869.53	-
3.2.1	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн мөнгө	129,974.95	
3.2.2	Бусад мөнгөн зарлага	17,937,894.58	
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны ЦМГ-ний дүн	(129,974.95)	-
4	Гадаадын валютын ханшийн зөрүү	96,491.22	-
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	138,336.82	300,847.74
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	12,923,238.91	13,061,575.73
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	13,061,575.73	13,362,423.47

2. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ТОДРУУЛГА**2.1 МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ**

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөнд Касс болон харилцах дансанд байгаа мөнгө, хугацаагүй хадгаламж, 3 сар хүртэлх хугацаагаар хязгаарласан тусгай зориулалт бүхий мөнгөн сан, үнэ цэнийг нь өөрчлөхөд өчүүхэн бага эрсдэлийг мэдэрдэг, мөнгөний тодорхой дүнд чөлөөтэй хувирдаг, хөрвөх чадвар сайтай, богино хугацаатай хөрөнгө оруулалт хамаарна. Эдгээр хөрөнгийг нэрлэсэн үнээр нь бүртгэнэ. Гадаад валютыг нэр төрөл тус бүрээр нэрийн данс нээж Монгол банкнаас зарласан тухайн үеийн ханшаар тооцон төгрөгт хөрвүүлэн төгрөг, валютаар давхар бүртгэнэ. Гадаад валютын үлдэгдлийг Монгол банкнаас зарласан ханшаар тухай бүр тэгшитгэн тооцоо хийж, гарсан зөрүүгээр тайлант хугацааны цэвэр орлого, зарлагад оруулна.

Тус байгууллага нь Голомт банк, ХАС Банк, ХХБанк болон Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвд харилцах данстай ба 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар дараах мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байсан байна. Үүнд:

Үзүүлэлт	Үлдэгдэл	
	2022.12.31	2023.12.31
Бэлэн мөнгө		
Касс 1001	522.54	37.62
Бэлэн мөнгөний үлдэгдэл	522.54	37.62
Харилцах		
Харилцах – 110201	857,401.37	1,117,756.03
Харилцах – 110202	10,978,493.03	10,966,493.03
Харилцах – 110203	36.15	36.15
Харилцах -110301	568,961.79	568,961.79
Харилцах - 110302	417,244.39	417,244.39
Харилцах - 110304	140,298.55	140,298.55
Харилцах -110305 ҮЦТХТ	8,000.00	16,000.00
Харилцах – 110306 ҮЦТХТ	42,408.90	42,408.90
Харилцах – 110307ҮЦТХТ	48,209.00	48,209.00
Харилцах дансны үлдэгдэл	13,061,053.19	13,317,407.85
Нийт мөнгөн хөрөнгийн дүн	13,061,575.73	13,317,445.47

Байгууллага нь харилцах дансны үлдэгдлийг аливаа зээлийн баталгаа болон бусдад барьцаалаагүй бөгөөд зарцуулалт нь хязгаарлагдаагүй болно.

2.2 ДАНСНЫ АВЛАГА

Дансны авлага гэж нийлүүлсэн бараа, ажил, үйлчилгээний үнэ, хүлээн аваагүй байгаа бусдаас авахаар хүлээн зөвшөөрөгдсөн тооцоо юм. Дансны авлагад үндсэн үйл ажиллагааны явцад борлуулсан бараа, бүтээгдэхүүн, үзүүлсэн ажил үйлчилгээний төлөө худалдан авагч болон холбоотой талаас авах авлага, ногдол ашгийн авлага, үнэт цаасны хүүгийн авлага зэрэг дүн орно.

Дансны авлагыг цэвэр боломжит үнэ цэнээр буюу мөнгөөр хүлээн авахаар тооцоолж буй цэвэр дүнгээр санхүүгийн байдлын тайланд харуулна. Дансны авлагууд тайлант хугацааны эцэст үлдэгдэлгүй байсан байна.

2.3 ТАТВАР, НДШ-ИЙН АВЛАГА

Татвар, НДШ-ийн авлага гэж тухайн аж ахуйн нэгжийн үйл ажиллагаатай холбоотойгоор үүссэн татвар, НДШ-ийн төлбөртэй холбоотой үүссэн тооцоо юм. Татварын төрөл тус бүрээр данс нээж бүртгэх ба Татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг цэвэр боломжит үнэ цэнээр илэрхийлнэ. 2023 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар дараах ангилал, үлдэгдэлтэй байсан байна. Үүнд:

Үзүүлэлт	Үлдэгдэл	
	2022.12.31	2023.12.31
Татварын авлага - ХХОАТ	177,128.25	177,128.25
Нийт татвар, НДШ-ийн авлагын дүн	177,128.25	177,128.25

2.4 БУСАД АВЛАГА

Бусад авлагад үндсэн бус үйл ажиллагаанаас үүссэн авлагууд байх ба цэвэр боломжит үнэ цэнээр илэрхийлнэ. Дансны бусад авлагуудад хувьцаагаарх хөрөнгө оруулалтаас бусад авлагыг бүртгэх ба 2023 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар үлдэгдэлгүй байсан байна.

2.5 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалыг өртөг ба цэвэр боломжит үнэ цэний аль багаар илэрхийлнэ.

Бараа материалын өртгийг жигнэсэн дундаж өртгийн аргаар хуваарилна. Бараа материалын өртөг нь худалдан авалттай холбоотой гарсан бүх зардлуудыг оруулж тооцно.

Бараа материалын дансанд түүхий эд материал, дуусаагүй үйлдвэрлэлийн шууд материал, шууд хөдөлмөр, үйлдвэрлэлийн нэмэгдэл зардлуудыг бүртгэсэн ба үлдэгдэл, ангилал тайлант хугацааны эцэст үлдэгдэлгүй байна.

2.6 САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ

Санхүүгийн хөрөнгө гэж тайлант үед хийх төлбөрийн хэмжээнээс давсан буюу түр зуур чөлөөтэй байгаа мөнгөн хөрөнгийг ашиг олох зорилгоор зарцуулж буй үйл ажиллагааг хэлнэ. Санхүүгийн хөрөнгийг НББОУС 32-т хөрөнгө оруулалт гэж тодорхойлсон байна.

Үнэт цаасаарх хөрөнгө оруулалт нь өрийн /бонд/ үнэт цаасаарх хөрөнгө оруулалт, өмчийн /хувьцаа/ үнэт цаасаарх хөрөнгө оруулалт гэсэн хэлбэртэй байна.

Тус байгууллага нь санхүүгийн хөрөнгөд арилжааны үнэт цаас, өөрийн эзэмшиж байгаа үнэт цаас болон хөрөнгө оруулалтыг бүртгэдэг ба 2023 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар дараах үлдэгдэлтэй байсан байна. Үүнд:

Үзүүлэлт	Үлдэгдэл	
	2022.12.31	2023.12.31
Арилжааны үнэт цаас	12,293,899.59	12,293,899.59

Борлуулахад бэлэн үнэт цаас	1,043,778,020.00	1,021,269,457.90
Нийт санхүүгийн хөрөнгийн дүн	1,056,071,919.59	1,033,563,357.49

2.7 УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ЗАРДАЛ, ТООЦОО

Урьдчилан төлсөн зардал/тооцоо гэж тухайн тайлант хугацаанд хамааруулан зардал гэж зөвшөөрч бүртгэхээс өмнө төлбөрийг нь урьдчилж төлсөн зардлыг балансын хөрөнгийн зүйл ангид хамааруулж, урьдчилж төлсөн зардал гэж үзүүлнэ. Ийм төрлийн зардлыг жинхэнэ хэрэгжилтэд суурилан дараагийн тайлант үеүдэд зардалд шингээнэ.

Мөн энэ ангилалд төлбөрийн баталгааны сан, барьцаа хөрөнгийн сан, эрсдэлийн сангуудад байршуулсан хөрөнгө буюу эрсдэлээс хамгаалахад зориулж тусгаарласан хөрөнгийг оруулж бүртгэнэ.

Тус байгууллагын бэлтгэн нийлүүлэгчид төлсөн урьдчилгаа төлбөр 2023 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар үлдэгдэлгүй байсан байна.

2.8 ҮНДСЭН ХӨРӨНГӨ

Үндсэн хөрөнгөд нэг жилээс дээш хугацаанд ашиглагдах, ашиглалтын боломжит хугацаа нь хязгаарлагдмал бизнесийн хэвийн нөхцөлд худалдах зориулалтгүй үйлдвэрлэл, үйлчилгээний болон түрээслүүлэх, захиргааны зориулалтаар ашиглагдах элэгдлийн үндсэн дээр өртөг, зардалд анхны үнээ аажмаар шингээж байдаг биет хөрөнгүүд байна.

Үндсэн хөрөнгийг анхны өртгөөр нь бүртгэнэ. Үндсэн хөрөнгийн анхны өртөгт худалдан авсан үнэ, түүнийг бэлтгэхтэй холбогдон гарсан аливаа шууд зардлыг оруулах ба мөнгөн хөнгөлөлтийг хасаж тооцон бүртгэнэ. Үндсэн хөрөнгийн элэгдлийг шулуун шугамын аргаар тооцоолж, хөрөнгө бүрийн өртгийг түүний үлдэх өртөг хүртэл бууруулдаг.

Биет хөрөнгийг худалдан борлуулах буюу түүний ашиглалтаас ирээдүйн эдийн засгийн үр өгөөжгүй болсон үед данснаас хасах ба энэ үед үүссэн олз, гарзыг тайлант үеийн ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрч бүртгэнэ. Санхүүгийн тайлангаар үндсэн хөрөнгийн үлдэгдэл 2023 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар дараах үлэгдэлтэй байсан байна. Үүнд:

Үзүүлэлт	Үлдэгдэл	
	2022.12.31	2023.12.31
Тавилга эд хогшил	6,500,000.00	6,500,000.00
Компьютер, бусад хэрэгсэл	3,228,800.00	3,228,800.00
Хуримтлагдсан элэгдэл	(5,435,102.02)	(6,407,902.02)
Нийт цэвэр үндсэн хөрөнгийн дүн	4,293,697.98	3,320,897.98

2.9 БИЕТ БУС ХӨРӨНГӨ

Биет бус хөрөнгөд биет шинж чанаргүй, тодорхойлогдох мөнгөн бус хөрөнгийг тухайн хөрөнгөтэй холбоотой эдийн засгийн ирээдүйн үр өгөөжийг аж ахуйн нэгж хүртэх магадлалтай, хөрөнгийн өртгийг найдвартай хэмжих боломжтой тохиолдолд хүлээн зөвшөөрч бүртгэнэ. Бүртгэхдээ НББОУС-20-ийн дагуу уг хөрөнгийг бодит үнэ цэнээр нь бүртгэнэ. Хэрэв анхны бодит үнэ цэнээр бүртгээгүй бол нэрлэсэн үнэ дээр зориулалтаар нь ашиглахад бэлэн болгохтой холбоотой шууд зардлуудыг нэмж бүртгэнэ. Тайлангаар

2023 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар биет бус хөрөнгийн үлдэгдэл байхгүй байсан байна.

2.10 ДАНСНЫ ӨГЛӨГ

Дансны өглөг нь НББОУС-т зааснаар өнгөрсөн үйл, ажил гүйлгээний үр дүнд бий болсон, ирээдүйд зайлшгүй төлөх, бусдын өмнө хүлээсэн үүрэг буюу санхүүгийн хариуцлага мөн бөгөөд тухайн тайлант үеийн нэрлэсэн үнээр тайлагнадаг. Тус байгууллагын санхүүгийн тайланд дансны өглөг тайлант хугацааны эцэст дараах үлдэгдэлтэй байсан байна. Үүнд:

Үзүүлэлт	Үлдэгдэл	
	2022.12.31	2023.12.31
Дансны өглөг - Адамас	45,688,270.00	45,688,270.00
Дансны өглөг – 22-р бааз ХК	19,279,749.00	19,279,749.00
Дансны өглөг – Иргэн Гүндэгмаа	33,607,240.00	33,607,240.00
Дансны өглөг – Иргэн Номундарь	120,447,372.00	162,547,372.00
Нийт дансны өглөгийн дүн	219,022,631.00	261,122,631.00

2.11 ТАТВАР, НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН ӨГЛӨГ

Татварын болон бусад улсын байгууллагад төлөх татвар, хураамжтай холбоотой өглөг, Нийгмийн даатгалын байгууллагад төлөх НДШ-тэй холбоотой өглөгийг бүртгэдэг. 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн өр төлбөр дараах байдалтай байсан байна. Үүнд:

Үзүүлэлт	Үлдэгдэл	
	2022.12.31	2023.12.31
Татварын өр - ХХОАТ	4,893,145.69	7,867,382.08
Нийгмийн даатгалын шимтгэлийн өр	5,218,559.32	15,467,239.32
Нийт татвар, НДШ-ийн өрийн дүн	10,111,705.01	23,334,621.40

2.12 БУСАД БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР

Бизнесийн үйл ажиллагаанаас өөр чиглэлээр үүссэн өр, бизнесийн үйл ажиллагааны явцад үүссэн төрөл бүрийн суутгалууд, зардалд шингээж тооцсон төлөгдөөгүй өр, урт хугацаат өр төлбөрийн тайлант хугацаанд хамаарах хэсэг, худалдан авагчид болон ажиллагчдаас авсан буцаан төлөх мөнгөн барьцаа, холбоотой талаас авсан богино хугацаат зээл болон дээр тусгайлан толилуулснаас бусад богино хугацаат өр төлбөрийг бүртгэх ба бусад богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэлгүй байна.

2.13 ЭЗДИЙН ӨМЧ

Өмчийг түүний нэрлэсэн үнээр тайлагнадаг. Нэрлэсэн үнээс илүүгээр төлөгдсөн дүнг нэмж төлөгдсөн капитал гэж бүртгэдэг. Ногдол ашгийг зарласан тайлант үед нь өр төлбөрөөр хүлээн зөвшөөрч бүртгэнэ.

Эздийн өмчийн дансны ангилал, үлдэгдэл дараах байдалтай байна. Үүнд:

Үзүүлэлт	Үлдэгдэл	
	2022.12.31	2023.12.31

Эзний өмч	300,000,000.00	300,000,000.00
Эздийн өмчийн бусад хэсэг	1,043,778,020.00	1,021,269,457.90
Тайлант үеийн хуримтлагдсан ашиг / алдагдал	(65,121,658.73)	(56,039,846.65)
Өмнөх үеийн хуримтлагдсан ашиг / алдагдал	(434,186,375.73)	(499,308,034.46)
Нийт эзний өмчийн дүн	844,469,985.54	765,921,576.79

2.14 ОРЛОГО БА ОЛЗ

Тайлангийн хугацаанд худалдсан бараа, бүтээгдэхүүн буюу гадагш үзүүлсэн ажил, үйлчилгээний орлого зэрэг байнгын, тогтмол үйл ажиллагаанаас олсон орлогыг борлуулалтын хөнгөлөлт, буцаалт болон үнийн бууралтыг хассан цэвэр дүнгээр орлогыг бүртгэнэ. Тайлант хугацаанд арилжсан үнэт цаас болон үнэт цаасны хүүгийн орлого дараах байдалтай байсан байна. Үүнд:

Үзүүлэлт	Үлдэгдэл	
	2022.12.31	2023.12.31
Брокерын үйл ажиллагааны орлого	228,000.00	500,354.66
Бусад үйл ажиллагааны орлого	9,750.00	-
Нийт орлогын дүн	237,750.00	500,354.66

2.15 БУСАД ОЛЗ (ГАРЗ)

Гадаад валютаарх дансуудад хийгдсэн ханшийн тэгшитгэлийн олз, гарз 2023 онд дараах байдалтай байсан байна. Үүнд:

Үзүүлэлт	Үлдэгдэл	
	2022.12.31	2023.12.31
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(169.95)	-
Нийт олз (гарз)-ын дүн	(169.95)	-

2.16 БОРЛУУЛАЛТ МАРКЕТИНГ БОЛОН ЕРӨНХИЙ УДИРДЛАГЫН ЗАРДАЛ

Борлуулалт маркетинг болон ерөнхий ба удирдлагын зардлыг ажиллагчдын цалин, нийгмийн даатгал шимтгэл, албан татвар, төлбөр, хураамж, томиллолт, бичиг хэрэг, шуудан холбоо, мэргэжлийн үйлчилгээ, сургалт, сонин сэтгүүл захиалга, даатгал, цахилгаан, ус, дулаан зэрэг ашиглалт, засвар, элэгдэл хорогдол, түрээс, харуул хамгаалалт, цэвэрлэгээ үйлчилгээ, тээвэр, шатахуун, хүлээн авалтын зардлууд, биет бус хөрөнгөөр хүлээн зөвшөөрөөгүй судалгааны болон хөгжүүлэлтийн зардал болон бусад гэж дэлгэрэнгүй тодруулна. Тус байгууллагын хувьд тайлант хугацаанд борлуулалт, маркетинг болон ерөнхий удирдлагын зардал дараах байдалтай байна. Үүнд:

Үзүүлэлт	Үлдэгдэл	
	2022.12.31	2023.12.31
Ажиллагчдын цалингийн зардал	24,240,000.00	43,980,000.00
Нийгмийн даатгалын шимтгэлийн зардал	2,769,760.00	5,344,240.00
Албан татвар, төлбөр хураамж	4,063,000.00	3,654,501.31
Шуудан холбооны зардал	1,436,421.35	-

Мэргэжлийн үйлчилгээний зардал	36,300.00	24,000.00
Ашиглалтын зардал	996,000.00	2,564,660.00
Элэгдэл хорогдлын зардал	972,800.00	972,800.00
Зар сурталчилгааны зардал	150,000.00	-
Нийт борлуулалт маркетинг болон ерөнхий удирдлагын зардлын дүн	34,664,281.35	56,540,201.31

2.17 САНХҮҮГИЙН ЗАРДАЛ

Тус байгууллага нь тайлант хугацаанд дараах санхүүгийн зардал гаргасан байна.
Үүнд:

Үзүүлэлт	Үлдэгдэл	
	2022.12.31	2023.12.31
Санхүүгийн зардал	110,400.00	-
Нийт санхүүгийн зардлын дүн	110,400.00	-

3. АУДИТЫН ТАЙЛАН

3.1 ОРШИЛ

Монголсекюритиес ҮЦК ХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг тус компанийн Гүйцэтгэх захирал Л.ГҮНДЭГМАА танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн шалгагдагчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

3.2 АУДИТ ХИЙХ ҮНДЭСЛЭЛ, ЗОРИЛГО, ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

Бид аудитын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1-д заасны дагуу Монголсекюритиес ҮЦК ХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

Монголсекюритиес ҮЦК ХК-ийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон НББОУС, СТОУС түүнд нийцүүлэн гаргасан байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Монголсекюритиес ҮЦК ХК-ийн удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС болон холбогдох бусад стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь хараат бус аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2024 оны 2 дугаар сарын 9-ны өдрөөс 2024 оны 3 дугаар сарын 29-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2024 оны 3 дугаар сарын 29-ний өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, ЦЭБЭ Консалтинг аудит ХХК-ийн аудитын баг хариуцаж хэрэгжүүлэв.

Монголсекюритиес ҮЦК ХК нь 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг ЦЭБЭ Консалтинг аудит ХХК-д 2024 оны 2 дугаар сарын 9-ны өдөр файлаар mnergui@gmail.com цахим хаягаас ирүүлсэн байна.

3.3 АУДИТЫН ЯВЦАД МӨРДСӨН БОДЛОГО, ЖУРАМ, АРГА ЗҮЙ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

3.4 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Тус байгууллага нь 1999 оны 12 дугаар сарын 15-ны өдөр анх байгуулагдсан. 2007 оны 8 дугаар сарын 17-ны өдөр Санхүүгийн зохицуулах хорооны даргын 112 тоот тогтоолын дагуу ТЗ 301/14 дугаараар үнэт цаасны зах зээл дээр брокер, дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авч үйл ажиллагаагаа өргөжүүлсэн байна.

Монголсекюритиес ҮЦК ХК нь "Монгол улсын үнэт цаасны зах зээлийг сонгодог утгаар хөгжүүлэх, хөрөнгө оруулагчдыг хүндлэн дээдлэх, үнэт цаасны шударга өрсөлдөөнт зах зээлийг бий болгож харилцагчдыг чанартай, түргэн шуурхай, найдвартай үйлчилгээгээр хангах"-д оршино гэж үйл ажиллагааныхаа зорилгоо тодорхойлсон байна.

Монголсекюритиес ҮЦК ХК нь байгууллагын дүрэмдээ үйл ажиллагааныхаа чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Гадаадын болон дотоодын хөрөнгө оруулагчдад үнэт цаас худалдан авахад зуучлах
- Хөрөнгө оруулагчдын нэрийн өмнөөс Монголын хөрөнгийн биржийн үнэт цаасны арилжаанд оролцох
- Компанийн харилцагчдын үнэт цаас эзэмшлийн бүртгэлийг хөтөлж мэдээлэл боловсруулах
- Үнэт цаасны зах зээлтэй холбогдолтой асуудлаар харилцагчдад үнэн зөв мэдээлэл, зөвлөгөө өгөх
- Үнэт цаасны зах зээлтэй холбогдолтой төрөл бүрийн гарын авлага боловсруулан гаргах

Тус байгууллага нь Үнэт цаасны тухай хууль, Компанийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Аудитын тухай хуулиуд болон татвар, нийгмийн даатгалын багц хуулиудын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна.

Санхүүгийн тайлангийн аудитын ажлын хугацаанд компанийн санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулга
- Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйл "нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ"

Байгууллагын улсын бүртгэлийн дугаар: **9010001014**

Байгууллагын регистрийн дугаар: **2587904**

Үйл ажиллагаа нь тогтвортой ажиллаж байгаа болно.

3.5 НИЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА БОЛОН ДОТООД ХЯНАЛТТАЙ ХОЛБООТОЙ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН ҮНЭЛГЭЭ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс шалгагдагчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг хангалттай гэж үзсэн болно.

Тус байгууллагад өнөөдрийн байдлаар Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй хэдий ч Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн эсэхийг судалж үзэхэд батлагдсан бодлого, журамд нийцүүлэн санхүүгийн тайланг бэлтгэсэн байна.

3.6 ТӨЛӨВЛӨЛТИЙН ШАТАНД ТОДОРХОЙЛСОН ЭРСДЭЛ, ТҮҮНИЙГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Аудитаар Монголсекюритиес ҮЦК ХК-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

3.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны жилийн эцсээрх санхүү байдлын тайлангийн нийт хөрөнгийн дүнг сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 1,050.4 сая төгрөгөөс материаллаг байдлыг 10.5 сая төгрөгөөр тодорхойлж, баталгаажууллаа.

3.8 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Монголсекюритиес ҮЦК ХК-ийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 23.2 сая төгрөгөөр буюу 2.1 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан санхүүгийн хөрөнгө, дансны өглөг, нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг, эздийн өмчийн дансууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	13.1	13.3	0.3
Татвар, НДШ-ийн авлага	0.2	0.2	-
Санхүүгийн хөрөнгө	1,056.1	1,033.6	(22.5)
Үндсэн хөрөнгө	4.3	3.3	(1.0)
Нийт хөрөнгө	1,073.6	1,050.4	(23.2)
Богино хугацаат өр төлбөр	229.1	284.5	55.3
Эздийн өмч	844.5	765.9	(78.5)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,073.6	1,050.4	(23.2)

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 13.3 сая төгрөг болж 0.3 сая төгрөгөөр өссөн нь 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр гадаад валютаарх харилцах дансны үлдэгдэлд гадаад валютын ханшийн тэгшитгэлийг хүлээн зөвшөөрч орлогоор бүртгэж авсантай холбоотой байна.

Дансны авлагад татварын байгууллагаас авах ХХОАТ-ын илүү төлөлт 177.1 мянган төгрөг бүртгэгдсэн байх ба Татварын байгууллагатай тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулаагүй байна.

Авлагын дансанд он удаан жил болсон найдваргүй авлага байхгүй болно.

Борлуулах зорилгоор бэлтгэсэн болон арилжааны үнэт цаас 1,033.5 сая төгрөг болж 22.5 сая төгрөгөөр буурсан байна.

Эргэлтийн бус хөрөнгө 3.3 сая төгрөг болж 1.0 сая төгрөгөөр буурсан нь тайлант онд байгуулсан элэгдлээс шалтгаалсан байна.

Богино хугацаат өр төлбөрийн данс нь 55.3 сая төгрөгөөр өссөн нь хувь хүнд өгөх өр 42.1 сая төгрөг, Нийгмийн даатгалын байгууллагад төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн өр 10.2 сая төгрөг, ХХОАТ-ын өр 3.0 сая төгрөгөөр нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Эздийн өмчийн өөрчлөлт нь тайлант үеийн алдагдлын хэмжээ нэмэгдсэн, эздийн өмчийн бусад хэсэг буурсан зэргээс шалтгаалжээ.

3.9 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Дараагийн аудитаар

- Санхүүгийн бүрдэл хангаагүй бичиг баримтаар тохируулгын бичилт, гүйлгээ хийсэн эсэх;
- Харилцах дансаар хийгдсэн гүйлгээг тооцооны дансаар дамжуулан зардлын дансанд бичилт хийсэн эсэх;
- Авлага, өр төлбөрийн үлдэгдлийг харилцагч байгууллагуудаар баталгаажуулсан эсэх асуудлуудыг авч үзнэ.

4. АУДИТААР ИЛРҮҮЛСЭН ГОЛ ЗӨРЧЛҮҮД, ТЭДГЭЭРИЙГ ШИЙДВЭРЛЭСЭН ТАЛААР:

Материаллаг байдлын түвшинд хүрсэн алдаа зөрчил илрээгүй байна.

5. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДЛУУД:

Аудит хийгдсэний дараа материаллаг түвшингийн хэмжээнээс давсан алдаа зөрчлүүд гараагүй болно.

Захирал



Д.ЭНХБААТАР

/Аудитор, МНБ/